



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 113

Мандалговь

**Хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэхь хэсгийн 6.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 1,112,262.00 (нэг сая нэг зуун арван хоёр мянга хоёр зуун жаран хоёр) төгрөгийн анхны өртөгтэй, 363,384.66 (гурван зуун жаран гурван мянга гурван зуун наян дөрвөн төгрөг жаран зургаан) мөнгөний хуримтлагдсан элэгдэл бүхий уурын зуух котелийн барилгыг акталж устгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Д.Мөнхтогтох)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хавсралтад заасан хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА *С.Сүхбаатар* С.СҮХБААТАР



Иймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
 2018 оны 10 сарын 10-ний өдрийн  
 113 дугаар тогтоолын хавсралт

Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн данснаас хасах үндсэн хөрөнгийн жагсаалт

Д	Хөрөнги	Ашиглал	Хэмж	Тоо	Нэгжийн үнэ	Балансын	Хуримтлагд	Үлдэгдэл	Данснаас	Актлах төрөл
/	йн нэр	танд	их	хэм		үнэ	сан элэгдэл	өргөг	хасах	1. Устгах
д		орсон	нэгж	жээ					болсон	2. Худалдах
		огноо							шалтгаан	3. Сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах 4. Бусад
1	Уурын зуух котель	1999	м2	1	1,112,262.00	1,112,262.00	363,384.66	748,877.34	Ашиглагд даггүй	1